

Golomt Capital®

# ДЭЛХИЙН

---

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ

2025.08.25

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- ХНС-ийн дарга Ж. Пауэлл инфляц ба хөдөлмөрийн зах зээлийн зөрчил төв банкны хоёр талт зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгож байгааг дурдав.
- Ж.Пауэллийн хэлснээр бодлогын хүү одоо “хязгаарлах түвшинд” хүрсэн тул бодлогоо өөрчлөх шаардлага гарч магадгүй.
- АНУ-ын PMI 55.4 болж, 31 сар дараалан эдийн засгийн идэвх өргөжсөн хэвээр байна. Үйлдвэрлэл 39 сарын дээд түвшинд хүрэв.
- Хятадын CSI 300 индекс 4.18% өсөж, 10 жилийн дээд түвшинд хүрэв. Шанхай +3.49%, Хонконг +0.27%.
- Хятадын өсөлтийг жижиг хөрөнгө оруулагчид тэжээж, маржин зээл 2015 оноос хойших дээд түвшинд хүрсэн нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>

### Биткойны зорилтот ханш 134,500 ам.доллар.

Golomt\_Capital created with TradingView.com, Aug 25, 2025 10:25 UTC+8

Bitcoin / TetherUS - 1W - BINANCE O113,493.59 H113,640.01 L112,159.00 C113,483.01 -10.58 (-0.01%) -10.58 (-0.01%)  
EMA (40, close) 99,487.69  
EMA (80, close) 84,909.49





## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.08.18-08.22

### ХНС-ЫН ТЭРГҮҮН ЖЕРОМ ПАУЭЛЛ ХҮҮ БУУРАХ МАГАДЛАЛТАЙГ ОНЦЛОВ

АНУ-ын Төв банкны дарга Жером Пауэлл Жэксон Холлын бага хуралд хэлсэн жилийн илтгэлдээ инфляцын дарамт болон хөдөлмөрийн зах зээлийн суларч буй шинж тэмдгүүд нь төв банкны “хоёр талт мандат” буюу инфляцыг хянах, ажил эрхлэлтийг дэмжих зорилтыг зэрэг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байгааг хүлээн зөвшөөрөв.

Гэсэн хэдий ч тэрээр эрсдэлийн тэнцвэр өөрчлөгдөж байгаа тул бодлогын байр сууриа өөрчлөх шаардлагатай байж магадгүй гэж онцоллоо. Пауэллын үзэж байгаагаар бодлогын хүү одоогоор “хязгаарлах түвшинд” байна.

### АНУ-ЫН БИЗНЕСИЙН ИДЭВХИ МАШ САЙН ҮЗҮҮЛЭЛТТЭЙ БАЙНА

S&P Global-ийн урьдчилсан мэдээллээр АНУ-ын бизнесийн идэвх 8-р сард энэ жилийн хамгийн өндөр түвшинд хүрч, PMI 55.4 болж 31 сар дараалан 50-аас дээш гарлаа.

- Үйлчилгээний PMI бага зэрэг буурч 55.4 болсон.
- Харин үйлдвэрлэлийн PMI 53.3 болж, сүүлийн 39 сарын дээд түвшинд хүрэн хүлээлтээс давлаа.

Энэ өсөлт нь эрэлт нэмэгдэх хүлээлт болон компаниуд үйлдвэрлэлийн нөөцөө нэмэгдүүлсэнтэй холбоотой. Гэвч орцын зардал 2024 оны 5-р сараас хойшхи хамгийн өндөрөөр өссөн бөгөөд гол шалтгаан нь гаалийн тариф. Компаниуд энэ зардлыг хэрэглэгчдэд дамжуулснаар бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 8-р сараас хойш хамгийн хурдтай өсөв.



### NASDAQ ИНДЕКСИЙН ХАНШИЙН ТӨЛӨВ ӨСӨХ ТРЕНДТЭЙ БАЙНА

NASDAQ: EMA 40 ба EMA 80 нь хаалтын ханшаас доор байрлаж, хүчтэй өсөх трендийг дэмжиж байна. EMA хоорондын зөрүү тэлж байгаа нь трендийн эрч хүч өндөр хэвээр байгааг илтгэнэ. Өмнөх дээд түвшнийг тестлэж, богино хугацааны буцаалт хийж байж дахин өсөх магадлалтай (healthy pullback).

Golomt\_Capital created with TradingView.com, Aug 25, 2025 10:14 UTC+8

Nasdaq 100 Index - 1D - NASDAQ 023,184.99 H23,575.36 L23,140.04 C23,498.12 +355.53 (+1.54%) +355.53 (+1.54%)  
EMA (40, close) 23,033.12  
EMA (80, close) 22,354.91





## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.08.18 – 08.22

### АНУ-БНХАУ-ЫН ХУДАЛДААНЫ ХАРИЛЦАА ТОГТВОРЖИЖ ӨСӨЛТ ҮРГЭЛЖИЛЛЭЭ

АНУ-Хятадын худалдааны харилцаа тогтворжсон нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, эрсдэл хүлээх сонирхлыг сэргээв. Үүний дүнд Хятадын гол индексүүд нэг долоо хоногийн дотор хүчтэй өсөлт үзүүлээ.

- CSI 300 индекс (дотоодын томоохон компаниудыг хамардаг) – 4.18% өсөж, сүүлийн 10 жилийн хамгийн өндөр түвшинд хүрэв.
- Шанхайн Composite индекс – 3.49% нэмэгдэв.
- Хонконгийн Hang Seng индекс – 0.27% өсөлттэй хаагдав.

### ӨСӨЛТӨД ЖИЖИГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ИХЭЭХЭН НӨЛӨӨЛЛӨӨ

Хятадын зах зээлийн өсөлтийг retail investors буюу жижиг хөрөнгө оруулагчид голлон хөтөлсөн. Үүний шалтгаан нь:

- Хүүгийн түвшин доогуур байгаа нь хадгаламжийг ашигтай байлгах боломжийг багасгасан.
- Хөрөнгө оруулалтын өөр сонголт хомс учир өрхүүд илүүдэл мөнгөө хувьцаанд чиглүүлж байна.

### МАРЖИН АРИЛЖАА 10 ЖИЛИЙН ДЭЭД ТҮВШИНД ХҮРЧ, ЭМЗЭГ БАЙДАЛ НЭМЭГДЛЭЭ

Bloomberg-ийн мэдээлснээр, маржин зээлээр хувьцаа худалдан авах хэмжээ (өр зээл авч хөрөнгө оруулах үзүүлэлт) сүүлийн 7 хоногт 2015 оноос хойших дээд түвшинд хүрчээ. Энэ нь зах зээлд оролцогчдын түвшин өндөр байгаа ч эрсдэлийн түвшин ч мөн адил нэмэгдэж буйг харуулж байна. Тиймээс өсөлт нь эерэг дохио боловч тогтвортой байдалд анхаарах шаардлагатай.



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

<http://eps.sh/cal> © 2025 Earnings Whispers